



**ТӨВ АЙМГИЙН  
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/107

Зуунмод

**Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх  
вакцинжуулалтын ажлыг эхлүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны, эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.5, 6.6 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 20-ны хооронд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгдсэн системийн дархлаажуулалтын төлөвлөгөөний дагуу стандарт, зааврыг баримтлан хийж гүйцэтгэхийг “Н бэлэг” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (Г.Цэндсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Мал эмнэлгийн тасаг (Э.Долгормаа)-д ДААЛГАХ нь:

3.1.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухаан, технологийн зохистой хугацаанд зааврын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах.

3.2.Халдварт, гоц халдварт, зооноз өвчний талаар зөвлөмж, зөвөлгөөг иргэд, малчдад хүргэж, өвчний хор уршийг таниулах, сурталчилах ажлыг зохион байгуулах.

3.3.Мал эмнэлгийн нэгдсэн системд дархлаажуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг бүртгэж, мал эмнэлгийн эмнэлгийн улсын байцаагч баталгаажуулсанаар үр дүнг тооцох.

3.4.Вакцинжуулалт хийсэн тухай мэдээ, тайлан холбогдох санхүүгийн баримтыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс журмын дагуу бүрдүүлэн авч аймгийн Мал эмнэлгийн газарт хугацаанд хүргүүлэх.

4.Багийн Засаг дарга, малчин мал бүхий иргэдэд ДААЛГАХ нь:

4.1.Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малчин, мал бүхий иргэдийг идэвхтэй оролцуулж, мал сүргийг бүрэн хамруулах ажлыг багийн хэмжээнд зохион байгуулах.

4.2.Мал, амьтны хашаа, хороо, хэвтэр, бууц, дэвсгэр, хөрзөн, төлийн пүнз, өвс тэжээлийн хашаа саравч, агуулах гэх мэт газруудын цэвэрлэгээг сайтар хийж, мэргэжлийн байгууллагатай хамтран халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, халдварт гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж ажиллах.

4.3.Өвчнөөр болон гэнэтийн аюулаар үхсэн, хорогдсон малын сэг зэмийг булж, шатааж устгуулах.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.САРАНГЭРЭЛ

